



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

2 - 5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

6 - 24

-
- 1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/* 7 – 8
 - 2. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/* 8 – 11
 - 3. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/* 11 – 23
 - 4. Байнгын хорооны тогтоолын төсөл /Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/* 23 - 24

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 10 дугаар сарын 10-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 03 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Б.Баярсайхан, Д.Батлут, Б.Бейсен, Б.Жаргалмаа, Ж.Чинбүрэн;
Чөлөөтэй: Д.Сарангэрэл;
Өвчтэй: Б.Саранчимэг.*

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга П.Анужин танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

П.Анужин: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Васгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн Дархлаажуулалтын албаны дарга О.Дашпагма нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

П.Анужин: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
56.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хошууч генерал С.Ганбямба, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.Гандирваа, Батлан хамгаалах яамны Хуулийн хэлтсийн дарга, хуулийн зөвлөх Г.Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Ганхүү, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Ц.Идэрбат, С.Чинзориг, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

П.Анужин: Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга П.Анужин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно.

П.Анужин: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 23 минут үргэлжилж, 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр 13 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

П.АНУЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”
танхим
12 цаг 03 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Анужин: Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52.9 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулъя.

С.Ганбаатар гишүүн ирсэн, Ц.Мөнх-Оргил гишүүн ирсэн, М.Оюунчимэг гишүүн ирсэн, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн, С.Одонтуяа гишүүн ирсэн, Ц.Туваан гишүүн ирсэн, С.Чинзориг гишүүн ирсэн, Ц.Идэрбат нарын гишүүн хуралдаа хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Нэг. Байнгын хорооны тогтоолын төсөл. Цаглавар батлах тухай.

Хоёр. 2024 оны улсын төсвийн төсөлд тусгагдсан хүүхэд хамгаалал, хөгжил, эх, нярайн тусламж үйлчилгээ, эх, хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийг дэмжих ажлын талаар Эрүүл мэндийн

болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын мэдээллийг сонсох байсан боловч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зүгээс хүсэлт ирж, төсвийн хуулийг өргөн барьсны дараа эдгээрийг хэлэлцүүлж өгөөч ээ. Боловсруулж дуусна гэдэг санал өгсний дагуу энэ асуудлыг хойшлуулж байна.

Түүний дараа, Дархлаажуулалтын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Дөрөвдүгээрт нь, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Эцэст нь Байнгын хорооны тогтоолын төсөл. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

М.Оюунчимэг гишүүн үг хэлье.

М.Оюунчимэг: Уг нь Нийгмийн бодлогын байнгын хороо хүүхэд хамгаалалттай холбоотой салбарын сайдын энэ асуудлыг хойшлуулах нь буруу. Хүлээж авахгүй байх хэрэгтэй шүү дээ.

Яагаад гэвэл өчигдөр бүлэг дээр Хууль зүй, дотоод хэргийн яамны зүгээс хүүхэд хамгаалалттай холбоотой нөгөө санкцуудыг нь чангатгахдаа төсөв, мөнгөтэй холбоотой, Гэр бүлийн

хуультай холбоотой асуудлуудыг өргөн барихаа танилцуулгуудаа хийсэн. Нэлээд олон асуудлууд байгаа.

Үүнийгээ төсөвтэйгөө уяад, дээрээс нь хүүхэд хамгааллын төсөв, энэ төсвүүдийг нь задлаад яг юунд нь хэдийг яаж зарцуулах юм. Нөгөө бүтэц, орон тоо, хүүхэд хамгааллын, хүүхдийн эрхийн байцаагчийн орон тоо энэ тэр дутуу байгаа гээд.

Тэгэхээр төсвийн дараа хийхээр чинь энэ утгагүй болчих юм биш үү.

Уг нь Монгол Улсын Ерөнхий сайдын чуулган дээр хэлсэн үгээс төсвөөс өмнө манай эмэгтэй гишүүд салбар яамныхантай хамтраад хүүхэд хамгаалал дээр зарим цогц арга хэмжээ авах саналуудаа гаргаад өгвөл зүгээр ээ гээд тэгсэн.

Нийгмийн бодлогын байнгын хороонд Их Хурлын даргын зүгээс чиглэл өгч байсан.

Эмэгтэй гишүүдийн зүгээс камержуулалтыг цогцоор нь шийдэх саналаа өчигдөр Монгол Улсын Ерөнхий сайдад өргөн барьчихсан байгаа.

Тэгэхээр энэ бүгд чинь өөрөө санхүүжилтгүйгээр хэрэгжихгүй шүү дээ.

Тэгэхээр өнөөдөр уг нь 10 сарын 19-н гэхэд хэлэлцээд эхэлчихнэ шүү дээ. Төсвийг.

Тэгэхээр би уг нь хүүхэд хамгаалалттай холбоотой, хөрөнгө зардалтай холбоотой асуудлуудыг эрүүл мэндийн салбарын багц дээр оруулаад ирсэн шиг бид нарт өнөөдөр уг нь өгөөд үүнийгээ судлаад, зарим дээр нь хаана яаж ажиллах вэ гээд явж баймаар байх юм. Тэгээд энэ дээр одоо яах ёстой вэ?

П.Анужин: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнтэй санал нэг байна.

Тийм ч учраас Байнгын хороо өнөөдөр хэлэлцэх асуудалд эдгээр асуудлыг оруулж ирсэн. Яамнаас санал гаргасан учраас Та бүхэндээ танилцууллаа.

Эхлээд бүгдээрээ хэлэлцэх асуудлынхаа цаглаварыг батлаад, түүний дараа хоёрдугаар асуудал дээр М.Оюунчимэг гишүүний хэлж байгаа саналаар горимын санал хураалт явуулах нь би зүйтэй гэж бодож байна.

Тэгээд гишүүдийн олонх хэлэлцэх нь зүйтэй гэж үзвэл энэ хоёр яамдаас бид мэдээллийг сонсох нь зүйтэй гэсэн байр суурьтай байна.

Хэлэлцэх асуудалдаа орьё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

2023 оны 10 дугаар сард байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглаварыг батална.

Цаглаварын төслийг Та бүхэндээ тараасан байгаа.

Цаглавартай танилцаж, цаглавартай холбоотой санал хэлж, асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хороогоор 10 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглаварыг баталъя гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Нэгдүгээр асуудлыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хэлэлцэх асуудлынхаа хоёрдугаарт орё.

Байнгын хороодын гишүүдийн зүгээс хоёр дахь асуудлыг хэвээр нь хэлэлцүүлэх тухай санал гаргасан.

Тэгэхээр санал хураалт явуулна.

Хэлэлцэх асуудлын дараалал. Х.Булгантуяа сайд аа, Та хүлээж байгаарай.

Хэлэлцэх асуудлын дараалалд 2024 оны улсын төсвийн төсөлд тусгагдсан хүүхэд хамгаалал, хөгжил, эх, нярайн тусламж үйлчилгээ, эх, хүүхдийн эрүүл мэнд хоол тэжээлийг дэмжих ажлын талаар Эрүүл мэндийн болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын мэдээллийг сонсох гээд хэлэлцэх асуудлын дараалалд орж ирсэн байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг хэлэлцэх нь зүйтэй гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд ээ. Санал хураалт.

Хоёрдугаарт оруулж ирсэн асуудлыг Байнгын хороодын гишүүдийн олонх хэлэлцэхийг хойшлуулъя гэсэн санал өглөө.

Хэлэлцэх асуудлын гуравдугаарт орё.

Хоёр.Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

/Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Ажлын хэсгийн ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсгийг Та бүхэндээ танилцуулъя.

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Сувдын Төгсдэлгэр, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Дангаагийн Баярболд, ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албаны дарга

О.Дашпагма гэсэн бүрэлдэхүүнтэйгээр хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал гаргах гишүүн байна уу? Нэрээ өгнө үү.

Нэг л зүйлтэй хуулийн төсөл орж ирсэн. Байхгүй байна.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууя.

М.Оюунчимэг: Надад нэг асуулт, нэг санал байна.

Асуулт нь, бид өмнө хэлэлцэхэд зөвхөн “А” вирус буюу халдварт өвчний эсрэг вакцин гэдэг утгаараа асуудал орж ирж байсан. Энэ дээр бид умайн хүзүүн хорт хавдрын эсрэг охидуудыг хамгаалах вакциныг энд оруулъя гэж ярьсан. Тийм ээ. Энэ асуудал маань энэ дээр цуг орж ирж байгаа юу?

Тэгээд хариултаа авчихъя. Тийм ээ.

П.Анужин: 3 номерын микрофонд Эрүүл мэндийн яам хариулт өгье.

С.Төгсдэлгэр: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр байна.

Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 3 өвчний эсрэг вакциныг товллолд нэвтрүүлэхээр орж байгаа.

“Гепатит-А”, “Хүний папиллома вирус” /Human papillomavirus (HPV)/, тэгээд “Пневмококкийн эсрэг вакцин” /Pneumococcal conjugate vaccines (PCV)/.

“Гепатит-А”-гийн вакцин гэдэг бол нөгөө **“бохирын шар”** гээд бидний хэлдгээр.

“Хүний папиллома вирус” гэдэг бол “эмэгтэйчүүдэд умайн хүзүүний хорт хавдар болон шулуун гэдэсний хорт хавдар”. “Эрэгтэйчүүдэд бэлгэ эрхтний болон бас шулуун гэдэсний хорт хавдар үүсгэдэг вирус” байгаа.

Мөн “эрэгтэй, эмэгтэй хүмүүст ам, залгиурын хорт хавдрыг үүсгэдэг вирусийн эсрэг вакцин”.

“Пневмококкийн эсрэг вакцин” нь “уушгины хатгаа өвчний эсрэг”.

П.Анужин: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулъя.

М.Оюунчимэг: Чуулган дээр хэлэлцэх үед өмнө нь ч гэсэн энэ гурав зайлшгүй орох ёстой гээд ихэнх нь санал нэг байсан учраас орж ирж байгаа энэ асуудлыг дэмжиж байна.

Тэгээд зарчмын зөрүүтэй санал байхгүй байгаа тохиолдолд анхны хэлэлцүүлгээр нь батлах санал л гаргаж байна.

П.Анужин: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгээс асуулт байна.

Энэ гурван вакцин товллолт вакцинд орж байгаа юм байна. Дархлаажуулалтын хуульд өөрчлөлт орж байгаа юм байна. Нэмэлтээр.

Энэ гурван вакциныг ингээд товллолт вакцин болгож байгаагийн ач холбогдол нь юу байгаа юм? Энэ чиглэлийн өвчлөлийн гаралт манай улсад хэдий хэмжээ байгаа юм? Нийт өвчлөлд эзлэх хувь нь ямар байгаа юм?

Ер нь энэ вакциныг хэдий хэмжээний улс орнууд яаж товллолт вакциндаа оруулсан тийм жишээ баримт юу байна гээд энэ талаар нэг хариулт өгөөч.

П.Анужин: Эрүүл мэндийн яам. 3 номерын микрофонд хариулт өгнө.

С.Төгсдэлгэр: Энэ вакцинуудыг нэвтрүүлснээр эдийн засгийн болон хүн амын өвчлөл, нас баралтын үзүүлэлтүүд нэлээн сайжрах тооцоолол байгаа.

“Гепатит-А”-гийн вакциныг бид 2011 оноос эхлээд тархвар зүйн заалтаар үе шаттайгаар нэвтрүүлж ирсэн.

Үүний үр дүнд хамгийн харагдаж байгаа томоохон үр дүн юу байна вэ гэхээр 2011 онд анх нэвтрүүлж байхад жилдээ 14 мянга орчим хүүхэд энэ “Гепатит-А”-аар өвдөж байсан бол 2022 онд 14 хүүхэд болж, бараг мянга дахин буурсан ийм үзүүлэлттэй байгаа.

Тэгэхээр энэ үнэхээр үр дүнтэй вакцин гэдэг нь батлагдчихсан зүйл.

Энэ “хүний папиллома вирус”-ийн эсрэг вакцины тухайд гэх юм бол Монгол Улс эмэгтэйчүүдийн умайн хүзүүний хорт хавдраар бүсдээ нэлээн өндөр өвчлөлтэй улс орны тоонд ордог.

Тэгвэл энэ вакциныг 14-өөс 19 насны эмэгтэйчүүдэд хийснээрээ папиллома вирусийн халдварын тархалтыг 86 хувиар бууруулж байна гэдгийг олон улсын судалгаанууд харуулж байгаа.

Тэгэхээр алсдаа их олон эмэгтэйчүүдийг умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх. Үүний зэрэгцээ эрэгтэйчүүдэд бэлэг эрхтний болон ам, залгиурын хорт хавдар үүсэхээс сэргийлэх үр дүнтэй вакцинууд байгаа.

П.Анужин: Эрүүл мэндийн яамнаас хариултыг сонслоо.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргалаа.

Зарчмын зөрүүтэй саналыг Та бүхэнд танилцуулъя.

Их Хурлын дэгийн тухай хуулийн 39.22-т хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй бол хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргалаа.

Энэ горимын саналыг дэмжих эсэхээр санал хураалт явуулъя. Гишүүд ээ. /алх цохив/

Х.Булгантуяа гишүүн горимын санал гаргая.

Х.Булгантуяа: Байнгын хорооны дарга саяын санал дээр миний төхөөрөмж эсрэг гарчихлаа. Дахин санал хураалт явуулж өгөх горимын санал гаргаж байна.

П.Анужин: Х.Булгантуяа сайдын гаргасан горимын саналын дагуу саяын явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцох томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүн дээ. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалтыг дахин явуулъя. Гишүүд ээ. Ахин санал хураалт явуулъя. Эцсийн хэлэлцүүлэгтэй нэгтгэн хэлэлцүүлэх талаар санал хураалт явуулъя. Гишүүд ээ. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр

өргөн мэдүүлсэн Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы

нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирыг томилж байна.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа орёё.

Гурав.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

/Засгийн газар 2022.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Засгийн газраас 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн хэлэлцэх хэсгийг хэлэлцэнэ.

Ажлын хэсгийг танхимд урьж оруулъя.

Ажлын хэсгийнхнийг Та бүхэндээ танилцуулъя.

Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаяр, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хошууч генерал С.Ганбямба, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.Гандирваа, Батлан хамгаалах яамны Хуулийн хэлтсийн дарга, хуулийн зөвлөх Г.Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Ганхүү, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр нар хүрэлцэн ирсэн байна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаяр танилцуулна. Микрофонд урьж байна.

Г.Сайханбаяр: Эрхэм Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Та бүхэн Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар танилцуулж байна.

Тус хууль нь 1994 онд батлагдаж, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль тогтоомжтой нийцүүлэх хүрээнд нийт 23 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус яамнаас боловсруулан Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Тус хуулийн төсөлд дараах эрх зүйн зохицуулалтуудыг тусгасан болно. Үүнд:

1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуультай нийцүүлэн тус хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын эмэгтэй албан хаагчийн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааг алба хаах хугацаанд оруулан тооцох болон дээрх хугацаанд төлбөл зохих Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тухайн үед мөрдүүлэхээр баталсан сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон сар бүр улсын төсвөөс хариуцан төлөх эрх зүйн зохицуулалтыг тусгуулахаар.

2.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдсон зааврыг батлан хамгаалах болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг тусгуулахаар.

3.Цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан насанд хүрээгүй байхдаа нас барсан тохиолдолд түүний оршуулгын зардал олгогдохгүй байгаа хуулийн хийдлийг засаж, тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт энэ талаарх зохицуулалтыг тусгах.

4.Цэргийн албыг 10-аас доошгүй жил хаасан цэргийн алба хаагч орон тоо зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэнд, түүнчлэн цэргийн алба хаах насны хязгаар хэтэрч ажлаас чөлөөлөгдвөл түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгох эрх зүйн зохицуулалтыг тусгуулах.

5.Мөн хуулийн зарим зохицуулалтыг холбогдох хууль

тогтоомжид нийцүүлэх зэрэг асуудлуудыг тусгуулахаар боловсруулсан болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулж төрийн бус байгууллагаас болон байгууллагын цахим сайтад байршуулж, иргэдээс санал авч, ажлыг гүйцэтгэсэн төрийн захиргааны төв байгууллагуудаас санал авч бүгд дэмжсэн болно.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт төсвийн ачаалал үүсэхгүй.

Цаашид төсвийн зардал буурах эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

П.Анужин: Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Цэндийн Сандаг-Очир гишүүнээр. Ц.Идэрбат гишүүн нэрээ өглөө. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Манай улсын батлан хамгаалахын салбар өөрөө маш чухал.

Улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдал гээд. Энэ утгаараа энэ салбарт ажиллаж байгаа хүмүүсийн нийгмийн хамгааллын асуудлыг онцгой анхаарах нь зүйн хэрэг.

Ялангуяа энэ асуудал бараг хоёр жил жоохон удчихлаа. Гийм ээ. Эртнээс л оруулж ирэх гээд. Тэгэхдээ нөгөө төсөвтэй уях ёстой гэсэн Сангийн яамны

байр сууриас болоод жоохон удаад байсан. Би үүнийг мэдэж байна.

Намайг Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга байхад бас энэ асуудал орж байна.

Сангийн яамны тэр байр сууриас болоод түр хойшлогдсон. Одоо тэгээд орж ирж байгаа юм байна. Ялангуяа цэргийн алба хааж байгаа жирэмсэн болоод хүүхдээ харж байгаа, асарч байгаа, нас барсан үеийнх нь тэтгэмж гээд зайлшгүй Эрүүл мэндийн даатгалаас өгөх ёстой санхүүжилтийн асуудлууд байгаа юм билээ.

Хүний хүмүүсийн тоо ч нэг их биш юм билээ шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр Та бүхэн маань одоо яг төсвийн төсөл Засгийн газрын хуралдаанаар орох үед энэ асуудлаа танилцуулсан уу?

Мэдээж төсөв хөрөнгө нэг их шаардагдахгүй ч гэсэн тодорхой хэмжээний мөнгө энд яригдаж байгаа шүү дээ. Энэ нь 2024 оны төсөвт суусан уу? Эсвэл тэнд сайд нарын зохицуулалтынхаа хүрээнд асуудлыг шийдчих боломжтой гэж үзэж байгаа юу?

Ер нь Засгийн газар дээр энэ байр сууриа ямархуу байдлаар танилцуулсан бэ?

П.Анужин: 3 номерын микрофонд хариулъя.

Г.Сайханбаяр: М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр ер нь энэ жирэмсний амралттай, декрет авсан хугацаанд цэргийн алба хаагчийн алба хаах

харилцааны асуудал эрх зүйн ямар нэгэн зохицуулалтгүй явсаар ирсэн.

Тэгээд үүнтэй холбоотой батлан хамгаалах салбар дотооддоо энэ хуулийн заалт байхгүй байсан учраас цэргийн цолны цалин олгодог ийм журам гаргаад мөрдүүлж өнөөдрийг болтол явж ирсэн юм.

Тэгэхээр цэргийн цолны цалин гэдэг бол тухайн офицер, ахлагчийн албан тушаалын үндсэн цалингийн тодорхой хувиудаар олгогддог. Цолныхоо байдлаас шалтгаалаад.

Харин нэгэнт жирэмсний амралтаа авсан хүнийг цэргийн албанаас халсан тушаал гаргадаггүй учраас энэ нь өнөөдрийг болтол мөрдөгдөж ирсэн. Гэхдээ хууль эрх зүйн хувьдаа цэргийн алба хаасанд тооцох ямар ч үндэслэл байхгүй байна гэж үзсэн.

Тийм учраас бид энэ асуудлыг оруулж ирээд ерөөсөө Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төр төлөхөөр, цалинг нь болохоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний түвшнээс тооцохоор.

Тэгэхээр жилдээ дунджаар 200 орчим эмэгтэй цэргийн албан хаагчид жирэмсэлж байгаа. Үүнийг нь тооцоод үзэх юм бол харьцангуй төсвийн хөрөнгийн хувьд бага.

Тийм учраас бид өмнө нь цэргийн цолны цалин олгож байсан тогтолцооноосоо шууд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төр хариуцаад явах юм бол цэргийн алба хаах харилцаа нь албажаад хуульчлагдаад тасрахгүй болно. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь, төсөвт ямарваа нэгэн дарамт байхгүй. Бид Засгийн

газрын хуралдаан дээр тодорхой танилцуулсан. Сангийн сайдаас санал авсан.

Сайд нар төсвийнхөө багцад шийдэх бүрэн боломжтой. Энэ бол нэг их төсөвт нөлөөлөх хэмжээний зардал биш.

Бид үндсэндээ нэг албан хаагчийн Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төр хариуцахад 11 орчим мянган төгрөг л гаргана гэсэн үг.

Тэгэхээр 200 орчим эмэгтэй цэргийн албан хаагчдын зардал гэхээр 3 сая орчим төгрөгийн л асуудал байгаа юм.

Цаад агуулгаараа цэргийн алба хаах харилцаанд тасрахгүй байх эрх зүйн том зохицуулалт л энэ заалт дээр сууж өгч байгаа юм.

П.Анужин: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнд тодруулъя.

М.Оюунчимэг: Г.Сайханбаяр сайд, энэ багийнханд талархаж байна.

Яагаад гэвэл 200-аад эмэгтэй албан хаагчдын нийгмийн хамгааллын асуудлын хойноос маш идэвхтэй хөөцөлдөж асуудлыг шийдэх гээд яваад байгаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч хэлсэн л дээ. Энэ энхийг сахиулах, ер нь Монгол Улсын батлан хамгаалах салбарт эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ нэмэгдэж байгаа, бас гүйцэтгэж байгаа үүрэг илүү чанаржиж, Монгол Улсын нэр хүндийг хүртэл өргөж байгаа гээд. Тийм ээ.

Тийм ч учраас бид нийгмийн хамгаалал чиглэлээр нь энэ хүмүүсээ онцгойлон анхаарч үзэх ёстой.

Тийм учраас манай Нийгмийн бодлогын байнгын хороо үүнийг цаг алдалгүй дэмжээд явчих нь зөв болов уу гэсэн саналаа хэлье. Баярлалаа.

П.Анужин: М.Оюунчимэг гишүүнд баярлалаа. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Би ганц хоёр зүйл тодруулъя.

Тэгэхээр 1994 онд батлагдсанаас хойш энэ салбарынхны улсууд ажилласан хугацаа нь тэгээд тасалдаад явж байсан гэсэн үг үү? Хүүхэд төрүүлсэн, жирэмсний декреттэй байх үедээ.

Тэгэхээр одоо ингээд энэ хууль батлагдаад эхэлбэл эндээс хойших асуудал ингээд шийдэгдэх юм байна.

Энэ өнгөрсөн хугацаанд ийм хүмүүсийн асуудлыг яах юм? Нөхөх юм уу? Ингээд хохироод үлдэх юм уу гэдгийг нэг тодруулж асууя.

Хэчнээн хэмжээний, хэдэн хүний асуудал яригдах вэ?

Төсөв хөрөнгө шаардагдахгүй л гэж байх шиг байх юм. Жишээ нь 3 дугаар зүйл дээр. Энэ чинь уг нь 6-хан л зүйлтэй хууль юм байна л даа.

3 дугаар зүйл дээр 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно гэж байна. Энд эх үүсвэр хэрэгтэй болно. Хэдий хэмжээний хүн хамрагдах шаардлага гарах вэ? Төсөв хөрөнгө, санхүүгийн асуудлыг нь яаж байгаа юм бэ? Энэ дээр нэг тодруулж өгөөч ээ. Ийм хоёр асуулт байна.

П.Анужин: Г.Сайханбаяр сайд. 3 номерын микрофонд хариулт өгье.

Г.Сайханбаяр: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулья.

Энэ ажилласан жилийг 1994 оноос хойш цэргийн алба хаагчийн жирэмслээд жирэмсний амралт, декреттэй байх хугацаандаа цэргийн алба тасраад явсан юм байхгүй.

Хамгийн гол нь Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдаад бүгд маш нарийн цахим бүртгэл, мэдээллийн санд ороод явж байгаа учраас энэ ажилласан жилийн шимтгэл нь төрийн албанаас гэдэг юм уу, төрд ажилласан хугацааныхаа цалин орлогоос эрүүл мэндийн даатгалын тодорхой шимтгэлүүд нь төлөгдөхгүй үлддэг байсан учраас үүнийг хэрвээ шинэ хуулийн дагуу энэ бүртгэлийг төрөөс хариуцах хэмжээгээр зохицуулалтыг нь хийхгүй бол хүндрэл үүсэх юм л гэж ингэж үзэж энэ заалтыг оруулсан байгаа.

Өмнө нь бид яасан бэ гэхээр өмнө нь 1994 оноос хойших хугацаанд декретийн амралттай байсан эмэгтэй албан хаагчдынхаа цолны цалинг нь олгоод, цолны цалингийнх нь хувиас нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төлүүлээд явж байсан байгаа юм.

Тэгээд одоо бид тэрийг нь ерөөсөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний жишгээр тооцоод эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төрөөс хариуцаад явчихъя гэсэн ийм л эрх зүйн зохицуулалтыг нь оруулж өгсөн.

Тэгэхээр цэргийн албаны хугацаа нь тасрахгүй. Өмнө нь тасарч байсан тохиолдол байхгүй байгаа юм.

Хоёрдугаарт нь, 18 сарын тэтгэмжтэй холбоотой асуудлыг бид тодорхой болгож байгаа. Өөрөөр хэлэх

юм бол өмнөх хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дээрээ цэргийн алба хаагч 10 хүртэл жил, 10 болон түүнээс дээш жил алба хаасан бол 18 сар хүртэлх нэг удаагийн тэтгэмжийг олгож болно гэсэн заалт.

Тэгээд цэргийн алба хаагч гэдэг бол их ерөнхий заалт. Хугацаат цэргийн албан хаагч, гэрээт цэргийн албан хаагч, офицер, ахлагч бүгд орчхож байгаа юм.

Тийм учраас энэ хуулийн асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам маань юуг юу гэж үзэж байгаа вэ гэхээр зэрэг цэргийн албан хаагчдын хуулийн тодорхойлолтоороо хугацаат цэрэг ч гэсэн 18 сарын тэтгэмж гаргах гээд өргөдөл өгөх болох юм бол үүнийг нь шийдэх хууль эрх зүйн үндэс наана чинь байгаад байна.

Гэрээт цэргийн албан хаагч ч гэсэн мөн ялгаа байхгүй. Гэтэл үүнийг нарийсгаад зааж өгөх ёстой. Жишээлбэл, офицер, ахлагч. Тэгээд жилийг нь зааж өгөх ёстой.

Гэтэл яг үнэндээ хуучин мөрдөж байгаа хууль дээрээ цэргийн алба хаагч орон тоо, бүтэц зохион байгуулалт, эрүүл мэнд болон цэргийн насны дээд хязгаарт хүрч тэтгэвэрт гарсан тохиолдолд, халагдсан тохиолдолд энэ тэтгэмжийг олгоно гэсэн ерөнхий заалт байна гээд. Үүнийг нь тодорхой болгоё гэсэн үүднээсээ энэ заалтыг оруулж өгсөн байгаа юм.

Офицер, ахлагч 10 ба түүнээс дээш жил гэж тодорхой болгож өгсөн.

Өмнө нь Батлан хамгаалахын сайдын төсвийн багцад тэтгэвэрт гарах хүмүүст олгох нэг удаагийн тэтгэмж төсөвт суудаг. Тэр суусан хүрээндээ асуудлаа шийдээд яваад ирж байсан.

Одоо ч гэсэн түүгээрээ үргэлжлүүлээд л шийдээд явна гэсэн үг. Тийм.

П.Анужин: Ц.Сандаг-Очир гишүүн тодруулна.

Ц.Сандаг-Очир: Тэгэхээр өмнө нь тэр цэргийн цолны цалинг нь олгож байсан. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр одоо олгохоор болж байна.

Энэ хоёрын зөрүү ямар байх юм? Бараг дордчихож байгаа юм биш үү? Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр олгоно гэдэг чинь. Энэний зөрүүг хэлээдхээч.

П.Анужин: Г.Сайханбаяр сайд. 3 номерын микрофонд.

Төсвийн зөрүү. Тодорхой хариулаарай. 3 номерын микрофон.

Г.Сайханбаяр: Бид өмнө нь цэргийн цолны цалинг нь декреттэй байх хугацаанд нь олгож байсан юм.

Тэгээд түүнээс нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хувиар нь тооцоод олгочхож байгаа юм. Тэр төлөлтийг нь хийгээд.

Одоо бид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоогоод, тэгээд түүнийхээ 2 хувиар тооцоод эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь л төрөөр төлүүлнэ.

Түүнээс биш нэг удаагийн тэр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний цалин олгохгүй. Түүнтэй жишиж эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төлснөөр л энэ асуудал хууль эрх зүйн цоорхой нь арилж байгаа.

П.Анужин: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Энэ хуулийн хийдлүүдийг арилгах гээд нэмэлт, өөрчлөлтүүд оруулж ирж байна.

Тэгээд яг энэ амьдрал дээр байдаг юмнууд л орж ирж байна л даа. Жишээ нь, ахмадуудтай уулзалт хийхэд яг л энэ асуудлыг, ялангуяа төрийн цэргийн байгууллагуудаас гарсан ахмадууд. Одоо ахмадууд гэж дээ, бид нараас ганц хоёр ах нар л хүмүүс байж байгаа шүү дээ.

Тэгээд ахмадын тоонд оруулахгүй байна. Ахмадын тэр халамж, үйлчилгээ хамаг юмнаас хоцорч байна гэсэн.

Тэгэхээр хуулийн өөрчлөлтөөр энэ шийдэгдэх юм байна гэж ингэж харж байгаа. Хилийн цэргийнхэнтэй уулзахад бас л энэ асуудлууд яригдаж байсан.

Тэгэхээр төрийн цэргийн бүх байгууллага энд орох уу? Цагдаа, шүүхийн шийдвэр, онцгой, хил гэдэг нэг ийм асуулт байна.

Тэгэхээр үүнтэй холбогдуулаад Засгийн газар дээрээ ч гэсэн та бол зөвхөн Батлан хамгаалах яамны төсөв, санхүүтэй холбоотой асуудлыг ярьж байна уу? Хилийн цэрэг гэхэд Хууль зүй, дотоод хэргийн яаманд харьяалагдаж байгаа. Цагдаа мөн тэнд харьяалагдаж байгаа.

Үүнтэй холбогдуулаад хуулийн энэ өөрчлөлтүүд ороод ирэхээр, төрийн цэргийн байгууллагууд бүгд ороод ирэхээр нөгөө Батлан хамгаалах яамнаас бусад яаманд харьяалагдаж байгаа цэргийн тэтгэвэрт гарсан хүмүүст бас адилхан үйлчлээд явахаар санхүү, мөнгөний хувьд хүндрэл юмнууд гарахаар байгаа юу? Яг танайх шиг

ингээд салбар дотроо зохицуулалтуудыг хийгээд яваад байгаа юу гэдгийг би асуух гээд байна.

Яагаад гэхээр цэргийн байгууллагад ажиллаад эрт тэтгэвэрт гардаг юм бол энэ төрийн цэргийн бүх байгууллагад хамрагдаж байгаа учраас энэ хуулийн өөрчлөлт ганцхан зэвсэгт хүчинд биш бүх төрийн цэргийн байгууллагад үйлчлээд эхэлбэл би нэлээдгүй тоо гарах болов уу. Санхүү, мөнгө энэ дээр ямархуу тооцоолол юмнууд байгаа бол оо?

Хийдлийг арилгах нь зөв. Яах аргагүй энэ бол нэлээн тийм гярхай харж оруулж ирж байгаа ийм өөрчлөлт байна гэж харж байгаа. Тийм.

П.Анужин: 3 номерын микрофонд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хариулт өгье.

Г.Сайханбаяр: Ц.Идэрбат гишүүний асуултад хариулья.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хамрах хүрээ гэж байгаа.

Энэ хамрах хүрээн дээр тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль дээр зэвсэгт хүчин, хилийн цэрэг, дотоодын цэрэг, шүүхийн шинжилгээний байгууллагууд, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, авлигатай тэмцэх болон онцгой байдлын асуудал эрхэлсэн гээд төрийн цэргийн байгууллагын болон хууль тогтоох байгууллагуудын алба хаагчид бүгд хамрагдана.

Үүнтэй холбоотой асуудлаар хуулийнхаа үзэл баримтлал, үндэслэлийг бид Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтарч баталсан.

Эрхэлсэн сайд нараас бүгдтэй нь, яамдтай нь болон ажлын албадтай нь ажилласан. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн асуудал хариуцсан сайд, Батлан хамгаалахын сайд гээд. Энэ хүрээндээ бүгд тооцоо, судалгаа гаргаж ирсэн.

Бүгд энэ төсвийнхөө дотроо зохицуулах боломжтой гэдэг дээр санал нэгдсэн байгаа.

Өмнө нь тодорхой хэмжээгээр. Жишээлбэл, одоо энэ 18 сар хүртэлх тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудал хэрэгжиж явж ирсэн. Тэр жишгээрээ тоо, хувь хэмжээ нь дунджаар бид урьдчилсан төлөвлөлтөөрөө дараа дараагийнхаа жилийн төсөвт суулгаад явдаг тэр төсөвт суусан дотроосоо л шийдээд шийдээд явах юм.

Тийм учраас нэмэгдэл ямар нэгэн төсөв, хөрөнгө шаардагдах зүйл байхгүй. Харин хуулийн цоорхойгоо ингээд хамтдаа залруулья л гэсэн ийм бодлогоор оруулж ирсэн.

П.Анужин: Баярлалаа. Хуулийн төсөлтэй холбоотойгоор гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбоотой. Асуултыг Содномын Чинзориг гишүүнээр дуусгая. Содномын Чинзориг гишүүн асуулт асууя.

С.Чинзориг: Би хоёр асуулт асууя.

Эмэгтэй цэргийн албан хаагчийн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцох гэж байгаа юм байна.

Энэ жаахан асуудалтай л юм орж ирж байгаа юм байна даа.

Хоёр дахь асуудал нь, жирэмсний болон амарсны амралттай байх хугацаа, хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс төлнө гэсэн байна л даа.

Тэгэхээр энэ чинь хоёр өөр зохицуулалт шүү дээ. А.Хишигбаяр аа.

Ялгахгүй юм уу? Тухайлбал, та нар ээжүүд мэдэж л байгаа. Эмэгтэйчүүд.

Миний ойлгож байгаагаар тэр жирэмсний болон амаржсаны амралттай байх хугацаа гэдэг чинь яг хуулиар байх хугацаа. Үүнийхээ цалин хөлс нь яг өөрийнхөө нөгөө тогтоогдсон цалин хөлсөө энэ хугацаанд авдаг биз дээ? Үгүй билүү?

Хоёрдугаарт, амралтын, тэгээд хуулиар олгогдсон хугацаанаас цааш өөрөө эх хүүхдээ 3 нас хүртлээ харна гэвэл тэр хугацааны чинь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож болно.

Яг хуулиар олгогдсон жирэмсний болон амаржсаны чөлөөтэй байх хугацааны шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцно гэдэг чинь энэ буруу, болохгүй.

Энэ хоёр өөр зохицуулалт шүү. Та нар өөрсдөө даатгалын улсууд, өөрсдөө эмэгтэйчүүд. Үүнийгээ надаар хэлүүлэлтгүй маш сайн мэдэж байгаа байх.

Нэг нь хуулийн хугацаатай, хуулийн зохицуулалттай амралт. Тэр хугацаандаа эх яг тэр өөрийнхөө үндсэн

цалингаасаа л тэтгэмж авдаг шүү дээ. Тийм биз дээ.

Нөгөөдөх нь өөрөө хүүхэд асрах чөлөөтэйгөө ажиллаж байгаа бол тэр цалин авахгүй. Цалингүй амралт өгч байгаа. Түүнээсээ хөдөлмөрийнхөө доод хэмжээгээр шимтгэл нь төлж болно.

Хуулийн зохицуулалттай тэр жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн хугацаатай амралттай хувийн хугацааны шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс гэж болохгүй.

Үүнийгээ тэр анхны хэлэлцүүлэг дээрээ яриад томьёолол өөрчлөх ёстой болов уу гэж.

Би хоёр өөр зохицуулалт шүү гэж хэлэх гээд байна.

Тэр 2 дугаар зүйл дээр холбоотой асуудал. Ажлаасаа чөлөөлөгдлөө. 18 сарын цалин хөлстэй тэнцэх нэг удаагийн тэтгэмжийг олгох нь л дээ.

Одоогийн төрийн албаны хуулиар чинь ийм зохицуулалт хийчихсэн. Бүх салбар дээр мөрдөгдөж байгаа шүү дээ. Тэр жишгээр явбал яасан юм.

Улсад ажилласан жилийнх нь улсад ажилласан жилтэй нь дүйцэх сарын тэтгэмж олгож байгаа шүү дээ. Төрийн албаны хуульд ингээд зохицуулчихсан юм. Тэр зохицуулалтаараа явбал яасан юм.

Мэдэхгүй. Яагаад заавал 18 сарынх гэж оруулж ирж байгаа юм.

Одоо тэр хуулиар чинь 15 жил ажилласан бол 15 сарын тэтгэмж, 18 жил ажилласан бол 18 сарынхаа тэтгэмжийг авдаг ийм зохицуулалт Төрийн албаны хуульд оруулчихсан шүү дээ. Тэр нийтлэг

зарчмаараа зохицуулагдаж явж болохгүй юм уу?

Энэ хүн чинь 18-аас дээш жил ажиллачихсан бол хохирно шүү дээ. Нөгөө талдаа бусад салбаруудтайгаа ч гэсэн ойролцоо нэг зарчмаар явах нь зүйтэй юм биш үү. Яагаад заавал 18 сар гэж оруулж ирж байгаа юм.

Би тэр ажилласан жилтэй нь дүйцэхүйц сарын тэтгэмж олгоно гэдэг тэр Төрийн албаныхаа хуулийн зохицуулалтаар явбал яасан юм гэсэн ийм хоёр асуулт.

П.Анужин: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. А.Хишигбаяр дарга хариулт өгье.

Дараа нь Батлан хамгаалах яам хариулаарай. А.Хишигбаяр дарга эхлээд энэ хоёр зүйл дээр хариулт авчихъя. Тодорхой хариулаарай. Товч.

А.Хишигбаяр дарга 1 номерын микрофон дээр суугаад хариулт өгчих.

А.Хишигбаяр: С.Чинзориг гишүүний асуултад хариулья.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. А.Хишигбаяр.

Өнөөдөр нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа ээжүүд жирэмсэн буюу амаржсаны тэтгэмж авч байгаа тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл авахгүй байгаа. Яг тэтгэмжээс нь.

Яагаад гэвэл тэтгэмжээс шимтгэлд суутгадаггүй.

Тийм учраас яг жирэмсэн амаржсан нийт тэтгэмж авч байгаа хугацаанд ажил олгогчийн төлөх

шимтгэлийн хувь хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс төлж явж байгаа.

Тэгэхээр энэ хуулийн тухайд зарчим нь болж байна гэдэг байдлаар манай яам санал өгсөн байгаа.

Тэтгэмжийн тухайд төрийн албан хаагчид яг ажилласан жилдээ ногдуулсан. Хэрвээ 10 жил ажилласан бол 10 сарын тэтгэмж, 15 жил ажилласан бол 15 сарын тэтгэмж аваад явж байгаа. Өнөөдөр.

П.Анужин: 3 номерын микрофонд Г.Сайханбаяр сайд үргэлжлүүлээд гүйцээж хариулт өгье.

Г.Сайханбаяр: С.Чинзориг гишүүний асуултад хариулья.

Ерөөсөө энэ хуулийн заалтаа л тодорхой болгож байгаа юм. Би түрүүн тайлбарласан л даа.

Цэргийн алба хаагч орон тоо, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт болон эрүүл мэндийн шалтгаанаар, мөн түүнчлэн насны дээд хязгаарт хүрээд халагдах юм бол 18 сар хүртэлх тэтгэмжийг нэг удаа олгоно гэсэн ийм хуучин ерөнхий заалт байсан юм.

Цэргийн алба хаагч гэсэн хугацаа байхгүй. Тэр нь жил ч байна уу, сар ч байхгүй.

Одоо бид яаж байна вэ гэхээр цэргийн албыг 10-аас доошгүй жил алба хаасан алба хаагчид гэж байгаа юм.

Тэгэхээр одоо байгаа энэ хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар бол хугацаат цэргийн алба хаагч нэг жил хүртэл алба хааж байгаа юм.

Тэгээд нэг жилийн хугацаанд алба хааж байтал “байлдагч” гэдэг орон тоо нь тухайн анги дээр ямар нэгэн өөрчлөлт ороод “буудагч байлдагч” гэдгийн орон тоо нь хасагдлаа гэж бодоход тэр “байлдагч” халагдлаа гэж бодоход өргөдөл бичих юм бол тэр нь бас нээлттэй.

Гэрээт цэргийн албан хаагч. Мөн ялгаа байхгүй. Хил дээр алба хааж байгаа гэрээт цэргийн албан хаагч орон тоо нь бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт ороод гэрээт цэргийн албан хаагчийн орон тоо байхгүй боллоо. Цэргийн албанаас халагдлаа. Нөгөө хүн 18 сарын тэтгэмж авъя гээд бичихэд энэ бас олгогдох ийм хууль эрх зүйн ерөнхий том заалт ингээд тусгагдсан байсан юм.

Тийм учраас бид цэргийн албыг 10-аас доошгүй жил алба хаасан гээд ингээд заачихаар зэрэг энэ бусад зүйлүүд нь тодорхой болоод зөвхөн офицер, ахлагч нар хамрагдах хүрээнд болоод явчхаж байгаа юм.

18 сартай холбоотой эрх зүйн зохицуулалт хуучин байдгаараа байгаа. Нөгөө талаар 18 сарын хэмжээ олгохтой холбоотой зохицуулалт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас тогтоосон тэр журам руу явчих боломжтой.

П.Анужин: С.Чинзориг сайд тодруулъя.

С.Чинзориг: Яах вэ дээ. Бид нар өмнө нь Нийгмийн даатгалын хуульд өөрчлөлт оруулаад миний үед энэ ээжүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нь дэмжье, орлогыг нь дэмжье гээд заавал даатгалд хамрагдаж байгаа эх хүүхдээ 3 нас хүртэл харж асарч байгаа бол тухайн байгууллага нь шимтгэлийг нь төлөх, сайн дурын даатгалд хамрагдагчид 50 хувийг нь өөрөө төлөх,

50 хувийг нь төр төлөх гээд оруулчихсан юм. Яг түүнтэй л дүйцүүлж л оруулж ирж байгаа юм байна. Би тэр 1 дэх заалтыг чинь тэгж ойлгоод байгаа юм.

Гэхдээ тэр чинь миний хэлээд байгаа хугацаа өөр шүү. Яг хуулиар олгогдож байгаа, тэтгэмж авч байгаа хугацааны цалин өөр. Чөлөөтэй энэ хугацаа чинь цалин нь өөр шүү.

Тэрийгээ та нар анхны хэлэлцүүлэг дээрээ засаж өөрчлөөрэй.

Хоёрдугаарт, тэр 3 дугаар зүйл чинь эргэж яримаар л юм байна. Ажлын хэсэг дээр.

10-аас доошгүй жил ажилласан хүнд 18 сарын тэтгэмж олгоно л гээд байгаа юм байна л даа. Тэрийгээ ч гэсэн 10-аас доошгүй жил ажилласан бол тэгээд заавал 18 гэхгүй тэр ажилласан жилтэй нь дүйцэх сарын тэтгэмж олгоно гэдэг асуудлыг ажлын хэсэгт.../минут дуусав/

П.Анужин: С.Чинзориг сайдын хэлж байгаа ялангуяа эхний зүйл, заалт маш чухал.

Хийдлийг арилгах гэж байгаа гээд уг хууль дээр байсан зүйл, заалтыг дордуулна гэвэл энэ өөрөө утгагүй зүйл болох учраас энэ тал дээр анхаарч ажлын хэсэг байгуулагдвал анхаарах нь зүйтэй гэсэн саналыг хүлээж авах нь зүйтэй гэж үзэж байна.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа.

Өөр хурал давхцаад байгаа учраас би дэмжих гээд ороод ирсэн. Тэгээд

асуултууд байна. Яг хэлэлцэж байх үед ажлын хэсэгтэй нь холбогдож асууна.

Миний тодруулах гээд байгаа зүйл бол маш энгийн.

Цэргийн албан хаагч цэргийн алба хаах хугацаандаа нийгмийн даатгалын шимтгэл, цалин хөлснөөс төлдөггүй эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор цэргийн тэтгэвэр тогтоолгоод хуулийн насанд хүрээгүй байхдаа нас барсан тохиолдолд түүнд оршуулгын зардал олгогдохгүй хуулийн хийдэл байгааг засах гэж байна. Зөв өө.

Ер нь цэргийнхнийг төлдөггүй биш зүгээр төрөөс хариуцдаг гэдэг ойлголт надад дандаа байдаг байхгүй юу. Энэ чинь бас төлөгдөж байна гэж ойлгож байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хийдлийг журмаар шаардлага байгаа болно гээд энэ танилцуулга дээр бичсэн байна. Журмаар орж ирэх юм уу? Энэ яг яаж шийдэгдэх юм? Миний нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, яг энэний доод талын чаптерт нь байна. Хөдөлмөрийн тухай хууль болон нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах тухай хуулийн бусад зохицуулалттай давхцуулан тэтгэмж авахаар байгааг өөрчилж нэг удаагийн тэтгэмж олгохтой холбогдуулан харилцааг хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй уялдуулан нарийвчлан тодорхойлох шаардлага байгаа болно.

Үүнийгээ та нар яг яаж давхардаад байгаа, давхардлыг яг яаж зохицуулах гээд байгаа вэ гэдэг дээрээ энэ удаад нэг мөр орж ирж шийдэхгүй бол зүгээр л ингээд ийм байгаа шүү гээд бидэнд мэдээлэл өгөөд явж болж байна уу, үгүй юү? Энэ дээр би тодруулж асууя.

Та нар миний ярьж байгаа юмыг ойлгож байгаа байх. Энэ танилцуулгын 2-т байгаа шүү.

Тэгээд асуух асуултууд хэдий байгаа ч гэсэндээ би даргаас зөвшөөрөл авч асуулт асуусан учраас дараа нь хэлэлцэх эсэх дээр би нэлээн асууя. Ажлын хэсэг дээр ажиллая.

Зүгээр энэ ташрамд хэлэхэд та нар цэргийн энгийн албан хаагчдын тухай яг ийм асуудлыг орж ирэхгүй бол одоо дэндүү оройтчихсон байгаа шүү.

Яг адилхан цэргийн офицеруудтайгаа, цэргийн албан хаагч нартайгаа адилхан хөл гарын сургууль хийдэг, адилхан халуунд халж, хүйтэнд хөрдөг цэргийн албан хаагчид. Нарийн яривал цэргийн албан хаагчдын ар гэрийн хүмүүс их байгаа.

Бас тэнд энгийн албан хаагчид байгаа. Тэр асуудал. Би их олон жил боддог юм. Ерөөсөө хаягддаг. Маш ялгаатай. Бүр эрс ялгаатай.

Одоо та нар эмэгтэйчүүдийг 47 нас гэж байна. Цагдаагийнхан бол бага цолтон 47 нас, дунд цолтон 52 нас, ахлах 55, дээд 57 гээд ингээд ялгавартай байгаа. Та нар ялгаваралгүй 47 гээд шууд оруулж ирж байгаа юм байна.

Тэгэхээр энэ юм чинь энгийн албан хаагч нарт бүр ингээд алсарч байгаа байхгүй юу. Хол харагддаг. Маш их гомдолтой байдаг. Энэ асуудал дээр бодож байгаа, судалж байгаа гаргалгаатай зүйлүүд байна уу?

Би детальный нарийвчилсан бэрхшээлүүдийг одоо ярих цаг алга байна. Маш их хураагдсан, хуримтлагдсан асуудлууд байгаа шүү. Би

ийм гурван зүйл дээр Та бүхний анхаарлыг хандаасай гэж би хүсэж байна.

П.Анужин: 3 номерын микрофонд Г.Сайханбаяр сайд хариулт өгье.

Г.Сайханбаяр: С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Тэр тэтгэвэр авагч гэдэгтэй холбоотой насны хуульчилсан хэмжээ байгаа шүү дээ. Манай цэргийн албан хаагчид ажилласан жилээрээ тэтгэвэр тогтоолгочихдог учраас тэр хооронд маш их зөрүү гарчихдаг.

Өөрөөр хэлэх юм бол 18 настай цэргийн албанд, төрийн тусгай албанд ажиллаж эхэлсэн хүн 25 жил эрэгтэй, эмэгтэй нь 20 жил ажиллаад тэтгэвэр авах эрх зүйн үндэс үүсчихэж байгаа.

Тэгэхээр 43 наснаас эхлээд л ерөнхийдөө өөрийн хүсэлтээр насны алба хаасан жил нь гүйцэх юм бол тэтгэвэр тогтоолгож болно.

Гэтэл 43 настай хүн тэр 60, 65 нас хүртэлх хугацааны хооронд тэтгэвэрт гарчихсан хүн мөртлөө тэр ахмад настны оршуулгын тэтгэвэр, тэтгэмж бусад зүйлүүдэд нь хамрагддаггүй. Та маш зөв ойлгож, зөв ярьж байна л даа.

Үнэхээр энэ хийдэлтэй зүйлийнх нь нэг зүйл нь л оршуулгын олговор байгаа юм.

Тэр хүн 45 настай тэтгэвэрт гарчхаад 60 хүртэлх насандаа нас барчихлаа гэж үзэхэд тэр хүний оршуулгын зардлыг нь л төр хариуцъя л гэж байгаа юм. Тэр нь ахмадуудад үйлчилж байгаа нийтлэг тэр заалт. Тэр заалтаас хоцорчхоод байдаг.

Яагаад гэвэл тэр хүн биологийн хувьд тэр насандаа хүрээгүй мөртлөө тэтгэвэр авагч болоод ахмад настан болчихсон. Яагаад гэвэл тэр хүн төрдөө алба хаагаад тэтгэвэр авагч болчихсон.

Тийм учраас энэ хийдлийг арилгах энэ заалт.

Хоёр дахь асуудал нь, тэр энгийн албан хаагчдын асуудал бас манай маш эмзэг асуудал. Гэхдээ жагсаал сургууль хийхгүй, буудлага, тусгай дадлага хийхгүй. Яг цэвэрлэгээ үйлчилгээ, гал тогоо, хоол хийх, үйлчилгээний ажил хийх, эмнэлэг, иймэрхүү байдлаар хийж байгаа.

Ер нь цэргийн ангийн хашаанд ажиллаж байгаа, алслагдсан салбарт ажиллаж байгаа энгийн албан хаагчийн эрх зүйн байдлын асуудал нэлээн чухал асуудал.

Цэргийн анги салбарт ажиллаж байгаа энгийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хууль гэдэг зүйл боловруулсан 2 жил гаруй бид нар дээр одоо байж байна.

Тэгээд оруулж ирэх нөхцөл бүрдэхгүй байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь, бид энэ цэргийн салбарт ажиллаж байгаа энгийн албан хаагчдын нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нэлээн сайн судлаад шийдээд яваад байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол тэр нэг удаагийн тэтгэмжийн асуудал орхигддог байсан. Одоо бүгд олгогдож байгаа.

Дээрээс нь тэр ажилласан жилтэй холбоотой асуудал байна. Дээрээс нь мөн тэр энгийн албан хаагчдын алслагдсанд

тооцсон нэмэгдлүүдийг олгодог болсон гээд. Тэр асуудлууд шийдэгдээд яваад байгаа учраас бид тусгайлан хууль гаргах шаардлагагүй юм байна. Ерөнхий хууль дотроо юмнуудаа шийдэгдээд явж байгаа юм байна гэсэн ийм байдлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай ажиллаж байгаа.

Ер нь байнга энэ дээр ингээд ажиллаад явж байгаа.

Дээрээс нь гэр бүлийн асуудал хөндөж байна. Гэр бүлийн асуудалтай холбоотой асуудлаар бас Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль дээр зааж өгсөн.

Тэр эрх зүйн байдлын тухай хууль дээр юу гэж заасан гэхээр цэргийн албан хаагчийн гэр бүл ажилгүй байгаа тохиолдолд олгодог нөхөн олговор гэж байгаа.

Хүүхдүүдэд нь зориулсан бас нөхөн олговор гэж байгаа. Эдгээр хуулиар хэрэгжээд явж байгаа.

Ер нь бид энгийн албан хаагчдын эрх зүйн байдалтай холбоотой асуудлыг анхаарах ёстой асуудал. Цогцоор нь бид нэг барьж авч үзсэн юм байгаа юм. Баярлалаа.

П.Анужин: Танилцуулгатай холбоотойгоор гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбоотойгоор үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд ээ. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдэж, уг хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хийлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийг томилж байна.

Хэлэлцэх асуудлынхаа сүүлийн асуудалд орцгооё.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх үүрэг бүхий

Ажлын хэсгийг байгуулах Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Та бүхэнд тогтоолын төслийг тараасан байгаа.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя гишүүд ээ. Санал хураалт.

Уучлаарай. Санал хураалтыг цуцалъя.

Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолыг Та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Сарангэрэл - Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн гишүүн:

Б.Жаргалмаа - Улсын Их Хурлын гишүүн

Мөнхөөгийн Оюунчимэг - Улсын Их Хурлын гишүүн

Жигжидсүрэнгийн Чинбүрэн - Улсын Их Хурлын гишүүн

Пүрэв-Очирын Анужин - Улсын Их Хурлын гишүүн.

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсэг /Д.Сарангэрэл/-т зөвшөөрсүгэй.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин гэсэн тогтоолыг танилцуулж байна.

Санал хураалт явуулъя. Гишүүд ээ. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдэж, тогтоол батлагдлаа.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаандаа идэвхтэй оролцсон нийт гишүүддээ баярлалаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хурал үүгээр өндөрлөж байна.

Хуралдаан 1 цаг 23 минут үргэлжилж, 13 цаг 26 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД